



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2018 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 05

Мөрөн

“Хөвсгөл Ус суваг” ХХК-ийн эдийн
засгийн үндсэн үзүүлэлт,
зорилтот түвшин батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 “к”, 20 дугаар зүйлийн 20.1, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.16, компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5.7 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Хөвсгөл Ус Суваг” ХХК-ийн 2018 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшинг 1 дүгээр, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар баталсугай.

2. Компанийн 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд үндэслэн бизнес төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлж, биелэлт үр дүнг 07 дугаар сарын 15, дараа оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор тайлагнахыг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

3. Компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хангахаар тавьсан зорилтуудыг гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээнд тусган, гүйцэтгэх захирлын гэрээг бүтэн, хагас жилээр дүгнэж, үр дүнг тооцохыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

4. Компанийн 2019 оны бизнес төлөвлөгөөний болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулж, 2018 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймгийн 2019 оны төсвийн төсөлд тусгуулахыг компанийн гүйцэтгэх захирал Г.Энхбаяр, Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

5. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга /Б.Болд/-д даалгасугай.

ДАРГА

Л.ТӨМӨРБААТАР



010655

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 01
дүгээр сарын 15-ны өдрийн 05 дугаар
тогтоолын хавсралт

ХӨВСГӨЛ УС СУВАГ ХХК-ИЙН 2018 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИН

№	Үзүүлэлт	хэмжих нэгж	2016 гүйц	2017 төл	2017 гүйц	биелэлтийн хувь	2018 оны төл	2017 оны гүйцэтгэлээс өссөн буурсан хувь
1	Үйлдвэрлэсэн цэвэр бохир ус	м3	51,723	185,299	161,826	87.33	169,191.6	4.5% өссөн
2	Зайлуулсан бохир ус	м3	46,330	140,211	135,064	96.33	141,367.8	4.6% өссөн
3	Гэр хорооллын цэвэр ус	м3	24,476	15,579	74,577	478.70	75,309.6	0.9% өссөн
4	Үйлдвэрлэсэн дулаан	М3	30,159	30,159	30,239	100.27	30239	өөрчлөлтгүй
5	Халуун усны үйлчилгээ	хүн	31,797	79,134	88,951	112.41	79,352	10.5% буурсан
6	Нийт орлого	төг	581,473,500	1,861,810,100	1,860,913,700	99.95	1,950,238,700	4.8% өссөн
7	Нийт зардал	төг	559,932,500	1,808,575,300	1,807,462,300	99.94	1,901,478,000	5.2% өссөн
8	Борлуулалтын /1төгрөгт ногдох зардал өссөн буурсан/	төг	1	1		-		
9	Орон нутгийн өмчийн ногдол ашиг	төг	-	17,400,000	17,400,000	100.00		
10	Авлага /бууралт/	төг	233,128,892	84,375,300	209,234,600	247.98	84,375,300	59.6% буурсан
11	Нийт өглөг	төг	2,617,454,800	2,617,454,800	2,486,515,400	95.00	2,486,515,400	
12	үүнээс богино хугацаат өглөг	төг	264,252,700	137,689,600	133,313,300	96.82	133,313,300	
13	Жилийн цэвэр ашиг, алдагдлын өсөлт бууралт	төг	19,386,799	56,234,800	53,451,400	95.05	53,451,400	
14	ИХ засвар ТЗБАХ, хөрөнгө оруулалт	төг						
15	Нийт ажилласадын тоо	төг	171	171	168	98.25	163	3% буурсан
16	Нийт цалингийн сан	төг	284,083,900	956,444,800	955,710,800	99.92	1,003,389,900	4.9% өссөн
17	Нийт зардалд цалингийн сангийн эзлэх хувь		50.74	52.88	52.88	99.98	52.76	0.12 буурсан